



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛГА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreathural@parliament.mn
http://www.parliament.mn

2022-06-09 № 28

Г Хувийн хэвшил, орон нутгийн эмнэлгийн
байгууллагуудад тулгамдаж буй
асуудлын талаар

Монгол Улсын хэмжээнд нийт 4,459 эрүүл мэндийн байгууллага байгаагаас 1,491 нь хувийн хэвшлийн эмнэлэг бөгөөд эдгээр эмнэлэгүүдэд эрүүл мэндийн салбарын ажилчдын 34.5 хувь буюу 18,7 мянган ажиллагсад ажиллаж байна.

Харин ЭМД-ийн Үндэсний зөвлөлийн 2022 оны 1 дүгээр сарын 28-ны өдрийн 01 тоот тогтоол гарсанаар иргэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хүртээмжтэй авахад хүндрэл учирсан, аж ахуйн нэгж байгууллагуудад ялгавартай хандсан зэрэг асуудлууд үүссэн байна.

Иймд эрүүл мэндийн даатгалын сангаас гэрээний үндсэн дээр эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, асаргаа, сувилахуйн сувилгаа явуулж буй хувийн хэвшлийн эмнэлэг, сувиллын байгууллагын үйл ажиллагаа, иргэдэд учирч буй хүндрэл, бэрхшээлийг шийдвэрлэх зорилгоор Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн Танд дараах асуулгыг тавьж байна. Үүнд:

1. Эмнэлгийн тусламж, үйлчилгээг нэр төрлөөр нь ялгавартай хандаж, онош болон үйлчлүүлэгчийн тоо, хэмжээг хязгаарласнаар иргэд тусламж, үйлчилгээг хүртээмжтэй авахад хүндрэл учруулж байгааг хэрхэн шийдвэрлэх талаар;

2. Өдрийн эмчилгээний зардалтай дүйцэхүйц хэмжээний зардлаар 1 хүний хэвтэн эмчлүүлэх зардлыг тооцож, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний зардалд суурь тариф тогтоон хязгаарлаж байгаа нь бодит тооцоо, судалгаанд үндэслэсэн эсэх, хавсарсан суурь өвчтэй хүмүүс хэрхэн эмчлүүлэх талаар,

3. Хувийн хэвшлийн эмнэлгийн байгууллага иргэдэд үзүүлсэн тусламж үйлчилгээндээ нэмэлт төлбөр авахгүй байхаар зохицуулсан нь эрүүл мэндийн үйлчилгээний чанар хүртээмж, олон улсын стандарт, шаардлагатай нийцэж байгаа эсэх талаар;

4. Эрүүл мэндийн тухай хуулийн 7.1.3-т заасны дагуу “Иргэд эмч, эмнэлгээ сонгох” эрхэнд халдан, эмчлүүлэх хүн бүрээс **13А маягтыг** шаардаж, хөдөө, орон нутагт хүндрэл үүсгэж байгааг хэрхэн шийдвэрлэх талаар;


5. Сонгон шалгаруулалтын 2 үе шатанд тавигдаж буй шаардлага нь орон нутгийн болон хувийн хэвшлийн эмнэлгүүдийн бодит нөхцөл байдалд нийцэхгүй, гэрээлэх боломжгүй байгааг хэрхэн шийдвэрлэх талаар;

6. Нөхөн сэргээх, Ковидын дараах нөхөн сэргээх үйлчилгээг хэрхэн даатгалд хамруулж байгаа эсэх талаарх зэрэг болно.

Энэхүү асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсэгт заасны дагуу ирүүлж, цаашид Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахад бэлтгэхийг Танаас хүсье.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН



Г.ТЭМҮҮЛЭН

Ё.БААТАРБИЛЭГ

Ж.МӨНХБАТ

Ж.ЧИНБҮРЭН

2022000066